

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2020 ОНЫ 02 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын мэдээлэл: Тайлант сард аймгийн онцгой комисс 9 удаа хуралдаж аймагт үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай 28 асуудлыг хэлэлцэн, холбогдох асуудлаар 11 шийдвэр, аймгийн Засаг даргын 8 захирамж, Онцгой комиссын даргын 6 тушаал, үүрэг хүргүүлэх болон холбогдох албан бичиг, баримтыг гаргаж хэрэгжилтийг ханган ажилласан.

Улсын Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар хуралдааныг зохион байгуулж олон нийтийг хамарсан уулзалт, сургалт, семинар, ёслол хүндэтгэл, урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулахгүй байх шийдвэрийг гарган хэрэгжилтийг хангуулан хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Аймаг орон нутгаас төлөвлөгдсөн олон нийтийг хамарсан арга хэмжээг түр хугацаагаар хойшлуулсан. Мөн Жаргалант сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 6 цахим тоглоомын газар, 18 биллъярдын үйлчилгээ эрхэлдэг газруудын үйл ажиллагааг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зогсоож байнгын хяналт тавин ажиллаж байна. “Хугацааг сунгах тухай” аймгийн Засаг даргын 2020 оны А/116 дугаар захирамжаар хот хоорондын зорчигч тээвэр болон хуваарьт нислэг, хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 08:00 цагаас 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 08:00 цаг хүртэл сунгаж, хяналтын постын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллалаа.

Хүнсний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар шийдвэрээр махны нөөц бүрдүүлэх ажлын хэсгийг байгуулж 300 000 000 төгрөг /гурван зуун сая/-ийн өртөг 43 тонн мах нөөцлөх үүрэг чиглэл өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Аймгийн Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар шийдвэрийн 3 дахь заалтаар төрийн алба хаагчдыг гадаадын сургалтанд хамруулахгүй, албан томилолтоор 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд ажиллуулахгүй байх үүрэг чиглэл өгч хэрэгжилтийг хангуулан ажиллав.

COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор ЭМЯ, ЭМХҮТ, НЭМҮТ-өөс хийсэн сэрэмжлүүлэг мэдээг видео болон фото хэлбэрээр Khovdtimes, khovdnews.mn, newkhovd.mn сайтууд, Ховд, Олон ястан, Жаргалант, ЭКО ТВ-ээр өдөрт 5 удаагийн давтамжтайгаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна. Орон нутгийн Ховд, Олон ястан, Жаргалант, ЭКО ТВ-үүдтэй хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулж гамшигтай холбоотой мэдээ мэдээллийг үнэн зөв, бодит байдлаар шуурхай нэвтрүүлэх үүрэг чиглэл өгч хяналт тавин ажиллаж байна.

Эдийн засаг, төсөв санхүүгийн мэдээлэл: Орон нутгийн төсвийн байгууллагуудын тайлант сард улсын төсвийн санхүүжилт 11756,6 сая төгрөг ирэхээс 10962,8 сая төгрөг ирж, цалин хөлс, тогтмол зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлээ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийн 1103,8 сая төгрөгийн санхүүжилтээс 310,0 сая төгрөгийн санхүүжилт ирж сумдад олголоо.

Сумдад санхүүгийн дэмжлэг 2663,1 сая төгрөг, аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагуудад 1235,3 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт сургууль 4674,4 сая төгрөг, цэцэрлэг 2268,5 сая төгрөг, хүн эмнэлэг 964,9 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 93,1 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 84,2 сая төгрөг тус тус олгосон.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/72 дугаар захирамжаар сум, байгууллагуудын 2 дугаар сарын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж, баазыг Сангийн яаманд хүргүүлж батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийн эрхийг нээлгэлээ. Мөн оны эцэст аймгийн төрийн сангийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн нэмэлт дансны үлдэгдэл 209,3 сая төгрөгийг байгууллагуудад аймгийн Засаг даргын А/71 дүгээр захирамжаар буцаан олголоо.

Сумдын 2019 оны орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл, зарцуулалтын тайланг маягтын дагуу гаргуулан баталгаажуулж, 5/257 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлэв.

Нягтлан бодогчдод санхүүгийн тайланг хуулийн хугацаанд боловсруулан Э-тайланд шивүүлэхэд анхаарч, зөвлөгөө өгч ажилласнаар тайлангийн шивэлт 60 хувийн гүйцэтгэлтэй байна. Аж ахуйн нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 1498 байгууллагаас хүлээн авч, баталгаажуулснаар ажлын гүйцэтгэл 82.0 хувийн хэрэгжилттэй байна.

Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 5655 ширхэг зардлын ваучер бичиж, 12950,2 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийж, 1442 аж ахуйн нэгж, хувь хүний мэдээллийг засварлаж, шинээр орууллаа.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “SMS” МТ үйлчилгээгээр төсвийн захирагч, нягтлан бодогч 300 гаруй хүнд мессеж хүргүүлэн чиглэл өгч ажилласнаар 25-ны байдлаар 146 байгууллага тайлангаа хоцроож, 1 байгууллага илгээгүй байгааг 3 дугаар сард нөхөж гаргуулах арга хэмжээ авч байна.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан Дотоод аудитын хорооны 5 дахь удаагийн хурлаар 2019 оны 4 дүгээр улиралд шалгагдсан Манхан, Мөнххайрхан, Алтай, Зэрэг сумдын 2016-2018 оны, Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2017-2018 оны, Гадаадын иргэн харьяатын баруун бүс дэх газрын 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүн, өмнөх шалгалтаар илэрсэн акт, албан шаардлагын хэрэгжилт, ажлын тайлан, 2020 онд хийх шалгалтын төлөвлөгөө зэрэг асуудлуудыг хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажиллалаа.

Аймгийн ИТХ-ын даргын 2019 оны А/21 дугаар захирамжийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ИТХ-ын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтаар тус байгууллагын 14,0 сая төгрөгийн авлага, 9,4 сая төгрөгийн өглөгийг баримтаар баталгаажуулж, хэрхэн барагдуулах талаар заавар, зөвлөмж өглөө.

Хөндлөнгийн мэдээллүүдийг цуглуулах, бүхий л эх үүсвэрийг татварын хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглаж хэвших, хөндлөнгийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлтийг хангаж ажилласнаар 16 хамаарагчтай 8 агуулагчтай татвар төлөгчийн 20 ширхэг 86.7 сая төгрөгийн хөндлөнгийн мэдээллүүдийг цуглуулав.

Боловсролын мэдээлэл: Аймгийн Боловсрол, соёл урлагийн газар бага ангийн математик, дүрслэх урлаг, хүн орчин, хүн байгаль, хүн нийгэм, монгол хэлний хичээлээр сургалтын хөтөлбөрийн агуулгын судалгаа хийж агуулга хоорондын залгамж холбоо, нэгж, бүлэг сэдэв бүрийн үнэлгээний шалгуур гаргаж, хичээллүүдийн даалгаврын сан боловсруулж байна.

Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэлийг судалгаа шинжилгээний үндсэн дээр бэлтгэх, сурагчдыг оношлох зорилгоор “Сорил–II”-ыг ЭЕШ авдаг 10 хичээлээр зохион байгууллаа. “Химийн сорил–II”-д нийт 166 сурагч хамрагдсан. Сумдын дундаж гүйцэтгэл 37 хувь, дээд гүйцэтгэлийн хувь 66, хамгийн бага гүйцэтгэл 12, 1 дүгээр сорилоос дундаж гүйцэтгэл 5 хувь ахисан, дээд гүйцэтгэл 2 хувиар буурсан хамгийн бага гүйцэтгэл 5 хувиар ахисан үзүүлэлттэй байна. Оролцогчдын тоо 17-оор буурсан байна. Аймгийн хувьд дундаж гүйцэтгэл 31%, дээд гүйцэтгэлийн хувь 56% хамгийн бага гүйцэтгэл 11% 1 дүгээр сорилоос дундаж гүйцэтгэл 6%, дээд гүйцэтгэл 5%, хамгийн бага гүйцэтгэл 3% -иар ахисан үзүүлэлттэй байна. Аймгийн дундаж 39 хувь буюу 11 хувиар өссөн байна. Даалгаврын гүйцэтгэлийн талаар дүн шинжилгээ хийж зөвлөмж хүргүүлээ.

Монгол хэлний хичээлийн сорилд аймгийн төвийн 79, сумдын 108, нийт 187 сурагч хамрагдлаа. Гүйцэтгэлийн хувьд сум 56.9 хувь, аймаг 58.2 хувь, нийт дундаж гүйцэтгэл 57.4 хувьтай үнэлэгдсэн. Нийт 25 сургуулиас 15 сургууль нь өмнөх сорилоос 1,6-28,4 хувиар ахисан бол 9 сургууль 1-26,3 хувиар буурсан байна. Аймгийн дундаж гүйцэтгэл өмнөх 1-ээсээ 7.9 хувиар ахисан байна. Сорилын анализ, зөвлөмжийг багш нартаа цахим хуудсаар хүргүүлээ.

Чанарын үнэлгээний шалгалтад тандалт хийх, I-II дугаар улирлын хичээлд шинжилгээ хийх зорилгоор 10 дугаар ангийн 605 сурагчдаас химийн хичээлээр хөндлөнгийн шалгалт авахад дундаж гүйцэтгэл нь 44%, мөн 10 дугаар ангийн биологийн хичээлээр 654 сурагчдаас шалгалт авахад дундаж гүйцэтгэл нь 50,7%-тай дүгнэгдсэн. 3 дугаар ангийн 1930 сурагчдаас хөгжмийн хичээлээр чанарын үнэлгээний шалгалт авахад аймгийн дундаж гүйцэтгэл 53,7 %-тай, хөдөөд 49,4% аймгийн төв 64,3%-тай байна, өмнөх жилийн чанарын үнэлгээтэй харьцуулбал 20.3%-иар өссөн үзүүлэлттэй байна

Монгол хэлний хичээлээр 9 дүгээр ангийн сурагчдаас чанарын үнэлгээний урьдчилсан сорилыг авахад, аймгийн төвийн 22 бүлгийн 561, хөдөөгийн 31 бүлгийн 654, нийт 53 бүлгийн 1369 сурагчаас 1215 сурагч буюу 88,8 хувь хамрагдаж, гүйцэтгэлээр сум 54.8 хувь, аймаг 53.5 хувь, нийт дундаж гүйцэтгэл 54.2 хувьтай үнэлэгдсэн.

БСШУСЯ-аас зохион байгуулж буй телевизийн цахим хичээлийн үр дүн, амралтын хугацаанд сурагчдын мэдлэгийг дэмжих зорилгоор сургуулиуд сурагчдаа хэрхэн хамруулан, эргэж нэмэлт тайлбар мэдээллийг хэрхэн өгч ажиллаж буй зохион байгуулалттай танилцах зорилгоор 7 хоног бүр утсаар холбогдон мэдээ мэдээлэл солилцон хамтран ажиллалаа.

Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгүүдийн телевизийн цахим хичээлд хүүхдийн оролцож буй байдал 63 хувьтай, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нарт ТҮ хичээлд хүүхдийг бүрэн хамруулах, багшид өгөх зөвлөмжийг онлайнаар 4 удаа хүргүүлж, мэдээллийг тухай бүх авч ажиллалаа.

Цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан Жаргалант сумын 13 дугаар цэцэрлэг, Бэмби, Хөх хулганы орон цэцэрлэгүүдэд Боловсрол, соёл урлагийн газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг ажиллаж, Бэмби цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоож, Хөх хулганы орон цэцэрлэгт ажил сайжруулах санал, зөвлөмж хүргүүлж, 13 дугаар цэцэрлэгийн зөвшөөрлийг сунгах санал дүгнэлтийг гаргалаа.

БСШУСЯ, БОАЖЯ, Швейцарын Хөгжлийн Агентлагаас 2019-2022 онд хамтран хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн хүрээнд Жаргалант сумын 1, 7, 2, Прогресс, Буянт, Мөст, Мөнххайрхан, Манхан сумдын сургуулиудыг хамруулах хүсэлт холбогдох материалуудыг бүрдүүлэн төслийн албанд уламжлаад байна.

2019-2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 9, 12 дугаар анги төгсөх өдрийн болон дүйцсэн хөтөлбөрийн нийт 2524 сурагчийн гэрчилгээ үнэмлэхийн захиалгыг авч намрын тоон мэдээлэлтэй тулгаж нягтлан нэгтгэлийг БСШУСЯ-нд хүргүүллээ.

2019 онд шүүхийн шийдвэрээр ял шийтгүүлсэн 32 хүүхдийн материалыг татан авч хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх дахин гэмт хэрэг зөрчилд холбогдохгүй байх талаар СНА-дад зөвлөгөө, мэдээлэл өглөө.

Боловсролын байгууллагуудын 2 дугаар сарын санхүүжилтийг нээж, БСШУС яамнаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу сургууль, цэцэрлэгүүдэд чиглэл хүргүүлж хоол, үдийн цайны ажиллахгүй хугацааны хэмнэлтийг хичээл нөхөх хугацааны илүү цагийн хөлсөнд шилжүүлж зарцуулах талаар чиглэл өгч, хөдөөгийн сургууль, цэцэрлэгийн багш, ажилчин сурагчдад 18041 ширхэг, аймгийн төвд 14600 ширхэг амны хаалтыг нийлүүлэх ажлыг хувиарлан зохион байгуулллаа.

Эрүүл мэндийн мэдээлэл: Тайлант сард Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал буюу шинэ корона вирус /Covid 19/ халдвар дэгдсэнтэй холбоотойгоор аймгийн онцгой комиссын хурлыг 9 удаа хийж, цаг үеийн мэдээллээр тасралтгүй

хангах “Шуурхай бүлэг”-ийг байгуулан ажиллуулж, хилийн боомт, залгаа сумдын эрсдлийн үнэлгээг хийлгэж үнэлгээний мөрөөр шаардлагатай 56 арга хэмжээг шийдвэрлэж халдварын үеийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулан аймгийн онцгой комиссын хурлаар хэлэлцүүлэн батлууллаа.

Мөн эрүүл мэндийн ажилтан албан хаагчдад халдварын үеийн шаардлагатай хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, тоног төхөөрөмжийн судалгааг Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлж, халдварын үеийн хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэн ажиллаж байна.

Халдвараас урьдчилан сэргийлэх, иргэдийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилгоор албан газрууд, нийтийн худалдааны газруудаар сурталчилгааны 3450 ширхэг материалыг тараан ил тод байршуулж, уушгины хатгалгаа өвчнөөс сэргийлэх №1-7 цуврал зөвлөмжийг аймгийн бүх сайтуудад байршуулан иргэдэд сурталчлах арга хэмжээг авч, төв 4 замын уулзварт 6.5м:3,5м, баруун бүсийн төв захын орчим 6м:3м, эмнэлгийн 4 замын уулзварт 3м:4м харьцаатайгаар байнгын сурталчилгааны самбарыг байршуулан иргэдэд сурталчилж давхардсан тоогоор урьдчилсан сэргийлэх мэдээлэл сурталчилгаа сургалтыг 156003 хүнд хүргээд байна.

Томуугийн болон шинэ вирусын халдвар дэгдэж байгаатай холбогдуулан сум, өрх, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлгүүдээс 7 хоног бүр томуу, томуу төст өвчний мэдээг нэгтгэн халдварт өвчин судлалын үндэсний төвийн томуугийн үндэсний төвд мягмар гараг бүрийн 11 цагт мэдээлж, өрх сумын эрүүл мэндийн төвүүдийг уртасгасан цагаар ажиллуулах арга хэмжээг авлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газраас санаачлан орон нутгийн дэмжлэгээр 1300 ширхэг гарын авлага, оёдлын үйлдвэр, цехүүдээр төв суурин газарт суурьшиж буй 58000 000 иргэдэд амны хаалтыг үйлдвэрлэн иргэдэд тарааж, эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай хамгаалах хувцас, ариутгалын бодис, халуун хэмжигч, нүдний шилийг нийлүүлэхэд шаардагдах 10.0 сая төгрөгийг шийдвэрлэж коронавирусын халдварын эрсдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг авлаа.

ДЭМБ-аас гаргасан коронавирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг зурагт хуудас видео хэлбэрээр, Эрүүл мэндийн газрын 1408 гишүүнтэй цахим хуудас, 99344 гишүүнтэй Ховд аймгийн нэгдсэн групп, 26 гишүүнтэй Ховдын эх барихын групп, 58 гишүүнтэй Цаст-Алтай цогцолбор сургуулийн групп зэрэг цахим хуудсанд байршуулж 2020 оны 02 дугаар сарын 21-ний байдлаар 15620 хүн мэдээлэл авсан байна. Орон нутгийн иргэдийг амны хаалтаар хангах, үнийн хөөрөгдлийг бууруулах чиглэлээр аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй 6 эм ханган нийлүүлэх байгууллага, 26 эмийн сангийн эрхлэгч нартай хамтран хариуцлагын гэрээ байгуулж ажиллалаа.

Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн эрүүл мэндийн байгууллагуудыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан хариуцлагатай жижүүрийг томилох Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны А/10

дугаар тушаал гарган 24 цагийн мэдээллийг авч нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна.

COVID-19 вирусийн халдварын бэлэн байдлыг хангах зорилгоор урьдчилсан байдлаар Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 55 ор, Булган сумын нэгдсэн эмнэлэгт 4 ор, Сумдын эрүүл мэндийн төвүүдэд 30 ор нийт 89 орыг дэлгэн ажиллуулахаар төлөвлөөд байна.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн <http://www.nccd.gov.mn/> вэб сайтын “БНХАУ-ын шинэ коронавирусын дэгдэлт”, “Хамгаалах хувцас хэрэгсэл”, “Шинэ коронавирусийн хариу арга хэмжээний эрсдэлийн үеийн харилцаа холбоо”, “Шинэ коронавирусийн халдварын сэжигтэй тохиолдлоос лабораторийн шинжилгээнд сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх”, “Шинэ коронаровирусийн халдварын тухай”, “Шинэ коронавирусийн халдварын үеийн халдварын сэргийлэлт хяналт”, “Халдваргүйтгэл” зэрэг хичээлүүдийг нийт 24 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж мэргэжлийн эмч мэргэжилтэн, олон нийтийг мэдээллээр хангах боломжийг бүрдүүллээ.

Халдварт өвчний тархвар зүй тандалт судалгааны хүрээнд халдварт өвчний тандалтын мэдээг хам шинжээр 7 хоног бүр нэгтгэн EWAR программд шивж, төвийн тандалтын албанд хүргүүлж, тайлант сард цэврүүт халууралт тууралттай хам шинж 3, шарлалттай хам шинж 1 тус тус мэдээлэгдсэн. “Тэмбүүг устгая” үйл ажиллагааны хүрээнд БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс тэмбүүгийн эрт илрүүлэг, үзлэгийн 14 хоногийн мэдээг сард 2 удаа авч нэгтгэн Халдварт өвчин судлалын үндэсний /ХӨСҮТ/ төвийн БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тандалт судалгааны албанд хүргүүлэн ажиллаж, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс тэмбүү өвчний сурталчилгаанд зарцуулахаар 3650 000 төгрөг төсөвлөгдсөнийг тэмбүү өвчний 4 төрлийн гарын авлага, сурталчилгааны материал, CD хувиан олшруулж эрүүл мэндийн байгууллагууд, Жаргалант сумын төрийн болон төрийн бус байгууллагууд, үйлчилгээний байгууллагуудад хуваарилан тарааж иргэдийн тэмбүү өвчнөөс сэргийлэх эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүллээ.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 19 дүгээр тогтоол болон Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/420 дугаар тушаалын даатгуулагчийн урьдчилан сэргийлэх багц үзлэгт Бэлгийн замын илрүүлэг үзлэг, шинжилгээ хийх насыг 18-65 нас хүртэл гэж өөрчилсөнтэй холбоотойгоор 2 дугаар сард багц үзлэгээр 17 хүн ХДХВ, тэмбүүгийн шинжилгээнд хамрагдаж, халдварт болон халдварт бус өвчний илрүүлэг үзлэгийг 2020 онд бүх сумдад зохион байгуулахтай холбогдуулан сум, өрхийн эрүүл мэндийн байгууллагаас 18-65 насны иргэдийн тоон судалгааг гаргуулан нэгтгэж, тэмбүү, ДОХ-ын хавсарсан оношлуур 19012ш, өндөг цоологч 14790 ширхэгийг захиалаад байна.

“Элэг бүтэн” Монгол хөтөлбөрийн хүрээнд 2017-2019 оны шинжилгээнд нийт 32732 хүн, С,В вирусын илрүүлэгт хамрагдсан 32066, 2020 оны 01 сард 467, 2 сард 183 хүн тус тус хамруулаад байна.

Эрүүл мэндийн салбарт судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэхэд анхаарч АШУҮИС-ийн НЭМС-ийн багш Ц.Энх-Оюун /АУ-ны доктор/, Б.Нямсүрэн

/МШУ-ны магистр/ нар “Эрүүл мэндийн байгууллагуудад судалгаа хийх арга зүй” сэдэвт сургалтыг 2 өдөр эрүүл мэндийн 80 эмч, мэргэжилтэн хамрагдаж Эрүүл мэндийн байгууллагад суурилсан судалгаа хийх мэдлэгийг нэмэгдүүллээ.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс өвөлжилтийн мэдээг авч Эрүүл мэндийн яаманд 14 хоног болгоны 5 дахь өдөр мэдээлж байгаа бөгөөд одоогоор эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой хүндрэл гараагүй байна.

Эхийн эрүүл мэндийг хамгаалах тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор Эрдэнэбүрэн, Буянт, Мөнххайрхан, Дуут, Үенч сумууд, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нөөц эх баригч нарыг 14 хоног, сум, өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж буй залуу эмч нарыг Амаржих газрын тэргүүлэх зэргийн эмч нарыг дагалдуулан 4 эмч, 2 лаборантыг ажлын байрны дагалдан сургалтанд хамруулах арга хэмжээг авлаа.

Сумын нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийн 2020 оны шаардлагатай 27 багцын 303.0 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурын тендэрт 11 компани шалгарч 1 дүгээр улирлын эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурыг хувиарын дагуу сумын эрүүл мэндийн байгууллагуудад нийлүүлээд байна.

Мөн Эрүүл мэндийн яам, Сангийн яам хамтран хэрэгжүүлж буй Ерөнхий гэрээний худалдан авалтаар 2020 оны 1 дүгээр улирлын шаардлагатай тоо хэмжээ бүхий 27 нэрийн эм, 2 нэрийн эмнэлгийн хэрэгслийг tender.gov.mn сайтын цахим дэлгүүр системээр дамжуулан захиалж, 6 компанийн 35,4 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг Эрүүл мэндийн газрын холбогдох мэргэжилтний хяналттайгаар хуваарилан сумын эрүүл мэндийн төвүүдэд түгээлээ.

2020 оны 2 дугаар сарын 15-ны байдлаар 36047 хүн үзлэг хийсний 6813 буюу 18.9 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байна, мөн үеийн байдлаар 172 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 3 тохиолдлоор нэмэгдэж, 173 нярай эсэн мэнд мэндэлж, нялхсын эндэгдэл 2 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 11.6 промилль буюу өмнөх оны мөн үеэс 11,8 промилээр, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 11,6 промилль буюу өмнөх оны мөн үеэс 11,8 промилээр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Халдварт өвчний 49 тохиолдол буюу 10000 хүн амд 5,5 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1,4 продицемилээр буурч, нийт халдварт өвчний 63,2 хувийг бэлгийн замаар дамжих халдвар, 1,2 хувийг сүрьеэ, 12,2 хувийг салхин цэцэг тус тус эзэлж байна.